



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Ардын чуулган намыг улсын бүртгэлд
бүртгэхээс татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, Г.Банзрагч, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Х.Сонинбаяр, Б.Ундрах, Г.Цагаанцоож, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардын чуулган намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг Захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгч Ч.Тунгалагийн илтгэснээр хэлэлцээд ТОДОРХОЙЛОХ нь:

Намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай Ардын чуулган намын даргаар сонгогдсон Ш.Сайхансамбуугийн гарын үсэг бүхий 2021.04.13-ны өдрийн өргөдлийг 2021.04.14-ний өдөр хүлээн авч, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 3.1-д заасны дагуу хянаж, 3.2-т зааснаар баримт бичгийн бүрдэл хангаж ирүүлэх хугацаа тогтоож, 2021.05.06-ны өдрийн 4/1654 дугаар албан бичгийг хүсэлт гаргагчид хүргүүлсэн байна.

Хүсэлт гаргагчаас, шүүгчийн шаардлагыг биелүүлсэн талаар тайлбар бичиж, Ардын чуулган нам үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай 2021.04.04-ний өдрийн огноотой өргөдөл гаргаж, 2021.05.14-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн бөгөөд өргөдөлдөө: “...Миний бие Ш.Сайхансамбуу нь 2021.04.04-ний өдрийн нам үүсгэн байгуулах хурлаар намын даргаар сонгогдсон, намыг үүсгэн байгуулсан, удирдах зөвлөлийн гишүүд 10,000,000 төгрөг хандивласан бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу зарцуулна, бидний ирээдүйн зорилгыг дэмжинэ хэмээн тус 807 хүн гарын үсгээ зурж ирүүлсэн, намын ирээдүйн зорилго бол Монгол Улс бүс нутгийн интеграци хамтын ажиллагаа, бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд өөрийн байр суурь оролцоогоо нэмэгдүүлэх, дэлхийн хөгжлөөс хоцрохгүй байх, улс төр, эдийн засаг, хөгжлийн тогтвортой байдлыг эрхэмлэн баримтлахад манлайлагч улс төрийн хүчин байна, миний бие Монголын ард түмний хүсэл зорилгод нийцсэн Ардын чуулган намыг байгуулах хүсэлтээ уламжилж байна, хүсэлтийг хүлээн авч нааштайгаар шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

Хүсэлтэд, намын дүрэм, намын мөрийн хөтөлбөр, намыг дэмжигчдийн бүртгэл /807 хүний гарын үсэг бүхий/, өргөдөл гаргагчийн мэдээлэл, Ардын чуулган намыг үүсгэн байгуулахаар санаачлагчдын хурлын протокол /2021.03.01-ний өдрийн/, үүсгэн байгуулагчдын хурлын тогтоол, протокол /2021.04.04-ний өдрийн/, үүсгэн байгуулагчдын мэдээлэл, намын нэр, бэлгэдэл, далбаа, тэдгээрийн утгын тайлбар, намын санхүүгийн асуудал эрхэлсэн ажилтны мэдээлэл, ажлын байр түрээслэх гэрээ, Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны Засаг даргын тодорхойлолт, намын хөрөнгийн мэдээ, улсын тэмдэгтийн хураамж төлсөн төлбөрийн баримт, хуулийн этгээдийн нэр баталгаажуулалтын хуудас зэрэг 173 хуудас бүхий 1 хавтас материалыг ирүүлжээ.

Хүсэлт болон түүнд хавсаргаж ирүүлсэн баримт, сонсох ажиллагаанд өгсөн хүсэлт гаргагчийн тайлбарыг судлан хэлэлцээд ХЯНАВАЛ:

Ардын чуулган намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах нь зүйтэй байна.

1.Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7-д зааснаар нам Улсын дээд шүүхэд бүртгүүлэхдээ “нам 801-ээс доошгүй гишүүнтэй болох”-ыг тодорхойлж, гишүүдийн бүртгэлийг ирүүлэх ёстой.

Шүүхэд ирүүлсэн “Ардын чуулган нам”-ыг дэмжигч 808 хүний бүртгэл нь тус намд гишүүнээр элссэн бус “дэмжигчид”-ийн бүртгэл байгаа нь Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7-д заасан “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/ байх шаардлагыг хангахгүй, сонсох ажиллагаанд оролцож, нам хэдэн гишүүнтэй талаарх шүүгчийн асуултад, намын дарга Ш.Сайхансамбуу, ерөнхий нарийн бичгийн дарга Д.Дуламсүрэн нараас хариулахдаа “намыг үүсгэн байгуулахаар санаачлагч 6 хүн тус намын гишүүн” гэснээс үзвэл, намын гишүүний тоо 801-д хүрээгүй тул Ш.Сайхансамбуугийн хүсэлт Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад нийцэхгүй байна.

2.Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “намыг зохион байгуулах Их Хурал /цаашид “үүсгэн байгуулах хурал” гэх/-аар үүсгэн байгуулна” гэж улс төрийн намыг хуулийн этгээдийн хувьд үүсгэн байгуулах аргыг заасан тул энэ хурлыг хуульд заасан журмын дагуу зохион байгуулах шаардлагатай.

Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан “намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах ба зохион байгуулж явуулах газар, хугацааг 2 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байх” шаардлагыг хэрхэн хангаснаа нотолсон баримтыг шүүхэд ирүүлээгүй, хүсэлтэд хавсаргаж ирүүлсэн 2021.03.01-ний өдөр №01 дугаар “Мэдэгдэл”-ээр “намыг үүсгэн байгуулах хуралдааныг 2021.04.04-ний өдөр 14.00 цагт Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, үйлдвэр чингисийн өргөн чөлөө гудамж Эс Эс АОС 1 байр, 1 тоотын хурлын 1-р танхимд хуралдуулахаар товлож иргэд та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна” гэх зар, Нам үүсгэн байгуулах хурлыг 2021.04.04-ний өдөр “Нарантуул илч” ХХК-ийн хурлын зааланд зохион байгуулсан, хурлын ирц 100 хувь, хуралд 23 хүн оролцсон тухайг тусгасан хурлын протокол нь хуулийн дээрх зүйл, заалтад нийцээгүй тул Ардын чуулган намыг үүсгэн байгуулагдсан гэж үзэхгүй.

Дээрх үндэслэлээр “Ардын чуулган нам”-ыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

“Ардын чуулган нам” нь нам үүсгэн байгуулах Их Хурлыг Улс төрийн намын тухай хуульд заасан журмаар дахин зарлан хуралдуулж, дээр дурдсан алдааг засч, холбогдох баримтыг бүрдүүлж, намыг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргахад энэ тогтоол саад болохгүй болно.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.6, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ардын чуулган намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.
2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр төлсөн 44,950.49 төгрөг, 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдөр төлсөн 105,049.51 төгрөг нийт 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөгийг төрийн сангийн төсвийн орлогод хэвээр үлдээсүгэй.
3. Энэ тогтоолд гомдол гаргах эрхгүйг дурдсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ, ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ТАНХИМЫН ТЭРГҮҮН, ШҮҮГЧ

Ч.ТУНГАЛАГ